



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН



ДАРХАН СУМ

2016 ОН

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ГҮЙЦЭТГЭЛДХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАЙЛАН**

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2015 оны тэргүүлэх зорилтуудын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны зорилт, хүрэх түвшинг гүйцэтгэлээр нь харьцуулан тогтоох, тэдгээрийн хоорондын алдаа, зөрүүг илрүүлэн дүн шинжилгээ хийж шалтгааныг тодруулан дүгнэлт зөвлөмж, гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Захиргааныбайгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”, Хүнс, Хөдөө Аж Ахуйн Сайдын 2015 оны А/85 тоот тушаал, хавсралтад дурдсан аргалчлалыг удирдлага болгов.

2.1 Хүнс, хөдөө аж ахуйн газрын Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт; /ХХАА-н салбарт хэрэгжиж буй 4 дэд хөтөлбөр/, хэрэглэгчийн үнэлгээ, Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн үнэлгээг АЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн өссөн болон тухай жилд хийхээр төлөвлөсөн арга хэмжээний үнэлгээгээр, Газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлт, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, Байгууллагын үйлажиллагааны ил тод байдлын тайлан, Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн заалт бүрийн биелэлтийн үнэлгээг газрын хяналт шинжилгээ-үнэлгээний багийн гишүүдээр хэлэлцэж, хэлтсүүдийн жилийн эцсийн мэдээ болон холбогдох албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлтэй харьцуулан үнэлгээг хийв.

ГУРАВ. ҮНЭЛГЭЭ

БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ

3.1.1 ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ/2013-2016 ОН/

Төлөвлөгөөнд тусгагдсан ХХАА-н салбарын нийт **18** зорилт,**41** хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт**84.6** хувиар үнэлэгдлээ.

Үүнээс хэрэгжилт хангалтгүй буюу 50 хувиас доош үнэлэгдсэн 2 арга хэмжээ байна.

Арга хэмжээгдурьдвал:

49.4 Дархан хотын гадна талд арьс, ширний үйлдвэрийн цогцолбор байгуулах, дэд бүтцийг барих ажлыг эхлүүлнэ. **Хэрэгжилт-30%**

Харин төлөвлөгөөний 44.2 дахь заалт “Хүлэмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгоно.”, 44.3 дахь заалт “Өвлийнхүлэмжбайгуулахаддэмжлэгүзүүлнэ.”, 47.1 дэхь “Мал нядалгааны нэгдсэн төв байгуулах судалгаа хийж, дэмжлэг үзүүлнэ.” гэсэн заалтуудын хэрэгжилт өмнөх онд хангалтгүй байсан бол ҮХААЯ-аас өнгөрсөн оны сүүлээр зарласан “Нарлаг хүлэмж байгуулах” төслийн шалгаруулалтад Дархан сумын “Суман хүзүүт” ХХК нь оролцож өвлийн хүлэмж байгуулах 36 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа явуулж байна. “Өвлийн хүлэмж байгуулах” төслийн сонгон шалгаруулалтад оролцож нийт 545.6 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг авснаар аймгийн хэмжээнд хүлэмжийн тариалах талбайн хэмжээ 12.5 хувиар нэмэгдсэн байна. Хүлэмжийн борлуулалт, тоног төхөөрөмжийг ханган нийлүүлэлдэг “Түмэн верум” ХХК-тай хамтран хүлэмжийг зах зээлийн үнээс хямдралтайгаар иргэдэд нийлүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласнаар 2 иргэнд хүлэмжийг хөнгөлөлттэй нөхцлөөр олгох ажлыг зохион байгуулсан. Мөн Хонгор суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Цайдам ургац” ХХКомпани нь хоногт 50 бод, 150 бог мал нядлах үйлдвэр барьж эхлээд байгаа бөгөөд 2016 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар зорилт тавин ажиллаж байгаа нь төлөвлөгөөний хэрэгжилт **84.6** хувь болж өмнөх оноос **21.6** хувиар өсөхөд нөлөөлсөн сайн талтай байна.

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ХХАА-Н САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ /2013-2016 ОН/
/2015 ОНЫ ЭЦСЭЭР/**

Д/д	Бодлого чиглэл	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх аргамжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжих шатандаа	Үүний дотор					Хугацаа болоогүй	Тасарсан		Үнэлгэ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн хүүсвэрээс	
1.	Үйлдвэржилтийн бодлого	5	10	2	8	4	4							84
2.	Хөдөө аж ахуйн бодлого	13	31	8	23	14	7	1	1					84.84
	Нийт дүн	18	41	10	31	18	11	1	1					84.6

3.1.2 “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР /2012-2016/ БАТЛАХ ТУХАЙ” АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2012.05.10-НИЙ ӨДРИЙН 39 ДУГААР ТОГТООЛЫН ХҮРЭЭНД 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Төлөвлөгөөний хүрээнд 12 зорилтын хүрээнд 14 хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийн дундаж **90.7** хувьтай үнэлэгдлээ. 30 хувьтай 1 заалт, 90 хувьтай 6 заалт, бүрэн биелсэн 7 заалт байна.

Хэрэгжилт хангалтгүй гарсан заалтуудыг авч үзвэл:

Зорилт 12. Органик хүнс, зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлэн бага насны хүүхдийн нэмэлт хоолны үйлдвэрлэлийг дэмжинэ.

Хэрэгжилт- Гурилыг 2003 оноос эхлэн амин дэм, эрдэс бодисоор баяжуулж эхэлсэн боловч баяжуулагч бодисны нийлүүлэлт зогссон байна.

2010 оноос сүүг зөгийн балаар баяжуулж эхэлсэн бөгөөд 2012-2013 онд 6,4 мян.л-ийг үйлдвэрлэсэн байна.

Хүүхдийн тусгай хоол үйлдвэрлэл, нэмэлт хоолны чиглэлээр төсөл ирүүлээгүй байна.

Органик хүнс, зохицуулах үйлчилгээтэй болон баяжуулсан хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлт аймгийн хэмжээнд хангалтгүй хэвээр байна. Хэрэгжилт-30%

Зорилт 4. Байгалийн гамшиг, эдийн засгийн тогтворгүй байдал, хүнсний хомсдлын үед хүн ам, ялангуяа эмзэг бүлгийн хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах,

Хэрэгжилт- Хүнсний тухай хуулийн 6-р зүйлийн дагуу “Хүнсний нөөц-сан бүрдүүлэх, зарцуулах, нөхөн бүрдүүлэх журам”-ыг боловсруулан батлуулсан байна.

2014 онд 1 үйлдвэрт 1000 тн мах, 6 үйлдвэрт 105,9 мян.тн буудай, 908 зооринд 11,0 мян.тн төмс нөөцөлж, ТЭДС-аас 14,4 мян.тн буудай нийлүүлсэн нь төмс, хүнсний ногоог, гурилаар бүрэн, 1-7 сарын хэрэгцээт махны 30-40 хувийг нөөцийн мах хэлбэрээр жишсэн дундаж хүн амын улирлаас хамаарах хүнсний хангамжийг бүрдүүлэн ажилласан байна. Мөн аймгийн ИТХ-ын даргын шийдвэрээр намрын ургац хураах хүртэлх хугацаанд 3 үйлдвэрт 257,4 тн гурил нөөцөлж, хомсдлоос сэргийлэх арга хэмжээ авсан байна.

2015 онд Байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол гамшгийн үед авах арга хэмжээ, хүнсний жагсаалтыг Аймгийн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгасан байна. Аймгийн хүн амын гамшиг ослын үед хэрэглэх 13 нэр төрлийн хүнсний хэрэгцээг Засгийн газрын 2006 оны “Хүнс, хангамжийн хэмжээг тогтоох тухай” 103-р тогтоолын дагуу тооцож, нийт иргэдийн 30 хувьд 3 хоногийн болон 14-20 хоногийн нөөц бүрдүүлэх хөрөнгийн тооцооллыг гаргаж **АИТХТэргүүлэгчдэд хүргүүлсэн боловч санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хэвээр байна.**

Зорилт 6. Хүнсний түүхий эд бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, борлуулах бүх дамжлагад хөдөө аж ахуй, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн зохистой дадлуудыг нэвтрүүлж, бүтээгдэхүүний эрүүл ахуйн баталгааг хангах, Хүнсний эрүүл ахуйн байдалд аюулын дүн шинжилгээ болон эгзэгтэй цэгийн хяналтыг нэвтрүүлэх.

Хэрэгжилт-2014.01.01-ээс мөрдөгдөж эхлэх хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлд зохистой дадал нэвтрүүлэх зорилтын хүрээнд 18 удаагийн сургалтаар сурталчилж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна. Түүхий эд, бүтээгдэхүүний бүртгэлийн дэвтрийг хөтлүүлж эхлүүлсэн байна.

Түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүн буюу мах боловсруулах 8 үйлдвэрт хөргүүрийн төхөөрөмжтэй зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх, борлуулах нөхцлийг 100 хувь, Дархан тээвэр ХХК, Мөнх халдун ХХК, Номин тав трейд ХХК, Өсөх нэхий ХХК зэрэг худалдааны 4 том газар температур хэмжигч бүхий хөргөх төхөөрөмжинд хадгалах нөхцлийг бүрдүүлээд байна. Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрүүд бүтээгдэхүүнийг зориулалтын 38 тээврийн хэрэгсэл, суудлын 35, ачааны 15 нийтдээ 91 машин ашиглагдаж байна. Мал тээвэрлэх ачааны 3 машин нэмэгдсэн байна. Дархан тээвэр ХХК-д хөргүүртэй агуулах шинээр ашиглалтанд оруулсан байна. 2015 онд түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 10 ААН хяналт шалгалтанд хамрагдснаар 6 буюу 60 хувь зориулалтын хөргүүртэй 14 тээврийн хэрэгслээр түүхий эд, бүтээгдэхүүнээ тээвэрлэж байна. Үүнд: 1-2 тн-ын даацтай

7ш, 1,5 тн-ын даацтай 2ш тээврийн хэрэгсэл хамруулсан боловч **зохистой дадлыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлсэн аж ахуй нэгжийн тоо хангалтгүй байна.**

“ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР ХҮРЭЭНД 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх арга эмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжихшатаандаа	Үүнийдотор					Хугацааболоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалтаас	Хөрөнгийнэхүү үсвэрээс	
1	Хүнсний аюулгүй байдал аймгийн дэд хөтөлбөрийн төлөвлөгөө	12	14	7	7	6			1					90.7

3.1.3 МОНГОЛ МАЛ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

“Монгол мал” Үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 12 заалттайгаар боловсруулан ХХААГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг 96,6 хувьтай ханган ажилласан байна. Үүнээс бүрэн хэрэгжсэн 8 заалт, хэрэгжих шатандаа 4 заалт байна. Төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсралтаар хүргүүлэв.

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх арга эмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжихшатаандаа	Үүнийдотор					Хугацааболоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалтаас	Хөрөнгийнэхүүс вэрээс	
1	Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		12	8	4	4								96.6

3.1.4 “ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2004 ОНЫ 26 ДУГААР ТОГТООЛ /2004-2015/

Аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн нийт **2** зорилт, **20** хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт **87,3** хувиар үнэлэгдлээ.

Үүнээс хэрэгжилт хангалтгүй буюу 50 хувиар үнэлэгдсэн 2 арга хэмжээ байна.

Арга хэмжээ тус бүрээр авч үзвэл:

7.1.1.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн ашиг орлогын нэмэгдүүлэхэд шинэ арга, технологи нэвтрүүлэх чиглэлээр эрдэм шинжилгээний байгууллагуудад судалгаа, шинжилгээний захиалга өгч, тэдэнтэй болон мал аж ахуйн мэргэжилтнүүд, үйлдвэрлэгчидтэй хамтран ажиллана. **Хэрэгжилт-50%**

7.1.1.11 Шинээр барих хашаа, байрны зураг, төсөл, түүнд тавих шаардлагыг орон нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохируулан боловсруулж, малчдад зөвлөмж болгон хүргүүлнэ. **Хэрэгжилт-50%**

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжсэнээр ололттой болон дутагдалтай талууд байна.

Давуу тал:

- Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2009 оны 36 дугаар тогтоолоор Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлогод аймгийн нутаг дэвсгэрийг Эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгаар тогтоосон.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар тогтоолоор “Шилдэг фермерийн аж ахуй эрхлэгч шалгаруулах журам”-ыг батлуулан ажиллаж байна.
- Дархан сумын ИТХТ-ийн 2013 оны 18 дугаар тогтоолоор “Дархан сумын ногоон бүсэд мал, тэжээвэр амьтан оруулахыг хориглох журам”-ын батлахад санал тусгуулсан бөгөөд хэрэгжүүлэхэд Аймгийн МХГ болон Дархан сумын ЗДТГазартай хамтран ажиллаж байна.
- Эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдийн судалгаагаар Дархан суманд сүүний үхрийн 8, мах, сүүний үхрийн 4, гахайн 7, тахиан 1, туулайн 1, Орхон суманд сүүний үхрийн 20, мах, сүүний үхрийн 5, махны үхрийн 7, бүдүүн,бүдүүвтэр ноост хонины 4, зөгийн 2 аж ахуй, 65 иргэн, хоршоо, Хонгор суманд сүүний үхрийн 7, мах, сүүний үхрийн 1, махны үхрийн 1, нарийн, нарийвтар ноост хонины 2, бүдүүн,бүдүүвтэр ноост хонины 3, гахайн 1, тахиан 1, Шарын гол суманд сүүний үхрийн 2, бүдүүн,бүдүүвтэр ноост хонины 1, гахайн 1, зөгийн 1 аж ахуйн иргэн, хоршоо үйл ажиллагаа явуулж байна.

Дутагдалтай тал:

- Малын тэжээлийн ургамал тариалах эзэмшлийн газар хомс байдаг.
- Гахай, шувуу аж ахуйг үржүүлэхэд олон найрлагат тэжээлийн үйлдвэр байгуулагдаагүй хэвээр байна.

“ЭРЧИМЖСЭН МАЛ АЖ АХУЙГ ДЭМЖИХ ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ”
АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2004 ОНЫ 26 ДУГААР ТОГТООЛ

Д/д	Бодлого чиглэл	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжихшатаандаа	Үүнийдотор					Хугацааболоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалтаас	Хөрөнгийнхүүсвэрээс	
1	“Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих дэд хөтөлбөр”	2	20	8	12	7	3	2						87.3

3.1.5 “ЧАЦАРГАНА АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2011.04.14-НИЙ ӨДРИЙН 23 ДУГААР ТОГТООЛ ХЭРЭГЖИЛТ

Хөтөлбөрт тусгагдсанаар нийт **3** зорилт, **7** хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилт **93.8** хувиар үнэлэгдлээ.

Үүнээс 100 хувийн хэрэгжилттэй 3, 90 хувийн хэрэгжилттэй 3, 70 хувийн хэрэгжилттэй 1 арга хэмжээ байна.

Хөтөлбөрийн ололттой болон цаашид анхаарах асуудлуудыг дурьдвал:

Ололттой тал:

- Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээр жимс жимсгэнэ түүний дотроос чацаргана тариалах сонирхолтой иргэд, аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдэж байна.
- Хөтөлбөрийн хүрээнд 2011-2015 оны хугацаанд “Чацарганы суулгац зээлээр олгох” төслийн тендерт 26 аж ахуйн нэгж, иргэн, хоршоо, нөхөрлөлд нийт 59175 ширхэг буюу 136.09 сая төгрөгийн суулгацыг зээлээр олгосон байна.
Бусад зээл, төсөл, тусламжаас 2009-2015 онуудад жимс жимсгэнэ тариалах чиглэлээр 13 төсөлд 168.0 сая төгрөг, боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 4 төсөлд 141.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэгийг үзүүлсэн байна.
- ХХААЯ, УГТХүрээлэн, ХААИС, МЧТҮҮХолбоотой хамтран жимс жимсгэний таримлын шинэ сортууд тэдгээрийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх чиглэлээр товхимол гарган үзэсгэлэн худалдаа 184, сургалт 225, уулзалтын үеэр 128 хүнд мэдээллийг түгээн ажилласан байна. Чацаргана болон бусад жимс жимсгэний сорт судалгааг эрчимжүүлэх, тухайн бүс нутагт тохирсон шилмэл сортыг сонгон шалгаруулах, тарьж ургуулах агротехнологи боловсруулах зорилгоор ҮХААЯ-наас УГТЭШХ-тэй гэрээ байгуулан 20 сая төгрөгийн санхүүжилт олгож “Чацаргана болон бусад жимс жимсгэний сорт судалгаа” төсөл хэрэгжүүлэн ОХУ, БНХАУ, Канад, БНСУ, Голланд улсын 6 төрлийн жимсний 35 сортын жимсний суулгац авчран, эх цэцэрлэг байгуулан аж ахуй, биологийн онцлогоор үнэлгээ өгч байна.

Цаашид анхаарах асуудлууд:

- Жимс, жимсгэний түүхий эдийн нөөцөнд тулгуурлан төр хувийн хэвшлийн хамтын дэмжлэгтэйгээр чацаргана боловсруулах үйлдвэр, цех байгуулах, тариалах хураах

ажлыг механикжуулах, хадгалах зоорь, хөргүүртэй агуулахын загвар цогцолбор аж ахуйг байгуулахад дэмжлэг үзүүлэх

- Инновацид суурилсан, шинэ мэдлэг шингэсэн эрчимжсэн чацарганы аж ахуйг байгуулах, чацарганы аж ахуйг хөгжүүлэхэд нэн шаардагдаж буй, арвин ургацтай шинэ сортуудыг эрдэм шинжилгээний байгуулагатай хамтран, нутагшуулах, үржүүлэх
- Чацарганыг эмийн ургамалтай хослуулан эрүүл мэндэд ашигтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар антиоксидант ялгаж, хүч тамир, дархлаа сайжруулах, эм бэлдмэл үйлдвэрлэх

“ЧАЦАРГАНА АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2011.04.14-НИЙ ӨДРИЙН 23 ДУГААР ТОГТООЛ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ /2015 ОНЫ ЭЦСЭЭР/

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх аргамжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжих шагандаа	Үүний дотор					Хугацаа болоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн хүүсвэрээс	
1	Чацаргана	3	7	7		6	1							93.8

3.1.6 АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙГ 2015 ОНД ХӨГЖҮҮЛЭХЭЭР ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Дархан-Уул аймгийн нийгэм, эдийн засгийг 2015 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө нь нийт 2 зорилт, 14 арга хэмжээ, 27 хэрэгжүүлэх ажилтайгаар боловсруулсан бөгөөд хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамааралтай 2 заалт орсон хэрэгжилтийн дундаж 95 хувьтай байна.

Д/д	Дэд хөтөлбөрийн нэр	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх арга эмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжих шагандаа	Үүний дотор					Хугацаа болоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн хүүсвэрээс	
1	Зорилт	2	2	1	1	1								95

БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

3.2.1 БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь нийт 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээс газар тариалангийн 7 заалтын хэрэгжилтийн дундаж 91.4 хувь, хүнсний 9 заалтын дундаж 96.6 хувь, мал аж ахуйн 10 заалтын дундаж 93 хувь, дотоод ажил үйлчилгээний 2 заалтын дундаж 100 хувьтайгаар хэрэгжүүлж **нийт дундаж 94.3** хувьтай хэрэгжүүлсэн байна.

Нийт арга хэмжээний 20 бүрэн, 5 заалт 90 хувь, 2 заалт 70 хувь, 1 заалт 50 хувь, огт хэрэгжээгүй заалт байхгүй байна.

Хэрэгжилт хангалтгүй буюу 50 хувьтай хэрэгжсэн 3.2 заалт “Төвийн бүсийн шилмэл малын үзэсгэлэн худалдааг аймагтаа зохион байгуулна.” заалт хөрөнгийн асуудал шийдэгдээгүйн улмаас хэрэгжээгүй харин аймгийн хэмжээний “Алтан намар” болон Улсын “Шилмэл мал”-ын үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож ХХААЯ-ны тусгай шагнал хүртсэн байна.

Ололттой талуудыг дурьдвал:

- ХХААЯам, Аймгийн ЗДТГазар, Монголын мастер тогоочдын холбоо, Аймгийн тогоочдын холбоотой хамтран “Аймгийн аварга тогооч” шалгаруулах тэмцээнийг аймагтаа анх удаа амжилттай зохион байгуулж 4 номинациар 12 байр шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.
- Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Сүүтэй-Монгол аяныг 12-р сарын 1 хүртэл зарласан ба энэхүү ажлын хүрээнд МХГ-тай хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж Дархан сумын сүү, цагаан идээ нийлүүлдэг болон ОУХТөвийн түргэн гэмтэх хүнсний бүтээгдэхүүн худалдаалдаг нийт 34 иргэнд хүнсний салбарын хууль эрх зүйн, сүү, сүүн бүтээгдэхүүнд хийгдэх шинжилгээ, үхрийн үүлдэр угсааг сайжруулах талаар мэдээлэл хийсэн.
- Олон улсын худалдааны төвийн мах, сүүний лангуунаас долоо хоног бүр дээж авч, МЭАЦ-ийн лабораторит зохих стандарт, зааврын дагуу шинжлүүлэн, хариуг өдөрт нь өгөх, хүнсний аюулгүй байдлыг ханган ажиллахаар хамтран ажиллах гэрээ байгуулж ажилласан.
- ХХААЯамны “Глабол коммунитес” ОУБ, “УГТЭШХүрээлэн” хамтран “Хонины ноосоор барилгын дулаалгын материал хийж ашиглах хангамжийн сүлжээг бэхжүүлэх төсөл, Аймгийн ХАА-н Хоршоологчдын холбоотой хамтран “Малын тэжээлийн ургамал тариалах технологи”, “Малчид, ноосон дулаалгын материал үйлдвэрлэгчдийн” сургалт, зөвлөгөөн, Малын удмын сангийн үндэсний төв”-тэй хамтран “Малын генетик чадавхийг сайжруулах зохиомол хээлтүүлгийн үйл ажиллагааг өргөтгөх” сэдэвт ярилцлага, “Саалийн үнээний фермертэй танилцах аялал”-ыг тус тус зохион байгуулан 120 гаруй малчид, фермерийг хамруулсан.
- Оношлогоо, шинжилгээний лаборатори нь 2 дахь удаагаа 3 жилийн хугацаатай итгэмжлэлд хамрагдсан. Итгэмжлэлийн хүрээг өргөтгөж 66 нэр төрлийн шинжилгээг орон нутагт хийх чадавхитай болгосон.
- “Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд 2015 онд төслийн тендерт Шарын гол сумын иргэн Хогноон овогтой Төмөрхүүгийн төсөл шалгарч 6.6 сая.төгрөгийн үнэ бүхий 3.1 мянган ширхэг суулгацыг гэрээ байгуулан олгосноор аймгийн хэмжээнд 154,1 га-д жимс жимсгэний үйлдвэрлэлийг эрхэлсэн.
- Дотоод журмыг шинэчлэн боловсруулж газрын нийт хамт олны хурлаар хэлэлцэж эцэслэн боловсруулж баталж, ажлын байрны тодорхойлолтуудыг ажлын хэсэг гарч шинэчлэн батлуулсан.
- Байгууллагын “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г газрын даргын 2015 оны 63 тоот тушаалаар батлуулсан.

- Мөн газрын Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2016-2025 он шинэчлэн газрын даргын 69 дүгээр тушаал баталж, хэрэгжилтийгүнэлэх журмыг хөтөлбөрт нэгтгэж оруулах ажлыг зохион байгуулсан.
- Мөн ББНШК-ийн ажиллах журам, Архивын дүрэм зэргийг шинээр боловсруулж архивын тухай хууль дүрэм, журмын хэрэгжилтийг сайжруулсан.

**БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ
/2015 ОНЫ ЭЦСЭЭР/**

Д/д	Үзүүлэлт	Нийт хэрэгжүүлэхархэмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжихшатаандаа	Үүнийдотор					Хугацааболоогүй	Тасарсан		Үнэлгээ
					90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалтаас	Хөрөнгийнхүүсвэрээс	
1.	Төлөвлөгөө	28	20	8	5	2	1						94.3

**3.2.2 ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДААС ХХААГ-ЫН ДАРГАТАЙ
БАЙГУУЛСАН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Гэрээ нь нийт 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээс газар тариалангийн 13 заалтын хэрэгжилтийн дундаж 86.1 хувь, хүнс үйлдвэрлэлийн 9 заалтын дундаж 96.6 хувь, мал аж ахуйн 23 заалтын дундаж 78.3 хувь, бусад чиглэлээр 7 заалтын дундаж 100 хувьтайгаар хэрэгжүүлж **нийт дундаж 86.9** хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжилт хангалтгүй буюу 70-аас доош хувь үнэлэгдсэн заалтууд нь мал үржил, ХАА-н бирж, газар тариалангийн салбарын зохион байгуулалтаас гадна хөрөнгө, мөнгө ихээр шаардсан, нэгдсэн зохион байгуулалт хийгдээгүй, зорилтыг өндөр тогтоосон заалтууд байна.

Хүнсний салбарын хувьд дийлэнх нь зохион байгуулалт шаардсан заалтууд байв.

Мал эмнэлгийн арга хэмжээний хувьд төсөвтэй уялдуулж хийгдсэн нь хэрэгжилт сайтай гарч байна.

Хэрэгжилт хангалтгүй буюу 70-аас доош хувь үнэлэгдсэн заалтуудаас дурьдвал:

- 17.Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт шинээр баригдаж буй Малын удмын сангийн үндэсний цогцолборын усан хангамжийн ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах
- 22.Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх 2015 онд хүрэх үр дүн: Бог малын 1,0 мянган хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлсэн байна.
- 40.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэлжүүлж гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх
- 49.Биржийн цахим арилжааны системийн онлайн горимыг ашиглан аймаг, орон нутгаас арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэхэд Хөдөө аж ахуйн брокерын

компанитай хамтарч ажиллах, шаардлагатай ажлын байр, талбай, мэдээллийн тоног төхөөрөмжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх гэх мэт.

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДААС ХХААГ-ЫН ДАРГАТАЙ БАЙГУУЛСАН
ҮР ДҮНГИЙНГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

Д/д	Салбар, чиглэл	Нийт хэрэгжүүлэх ажамжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжих шаандаа	Үүний дотор					Хугацаа болоогүй	Тасарсан		Үнэлгээ
					90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохион байгуулалтаас	Хөрөнгийн хүүсвэрээс	
1.	Хүнсний үйлдвэрлэл	9	6	3	3								96.6
2.	Газар тариалан	13	7	6	2	2	2						86.1
3.	Мал аж ахуй	23	11	12	2	4	3	2	1				78.3
4.	Мал эмнэлэг	4	3	1	1								97.5
5.	Бусад	7	7										100
6.	Нийт	56	34	22	8	6	5	2	1				86.9

3.2.3 АЙМГИЙН ХХААГ-ААС СУМДЫН МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГТАЙ БАЙГУУЛСАН ТУХАЙН ЖИЛИЙН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

ХХААГазар нь тус аймгийн 4 сумын Засаг дарга, МЭҮТ тасаг 2015 онд хамтран ажиллах гэрээг шалгуур нийт 12 үзүүлэлтэйгээр байгуулж хэрэгжилтийг жилийн эцэст дүгнэж ажилласан байна.

Үнэлгээгээр Дархан сум 101.2, Хонгор сум 105, Орхон сум 132, Шарын гол сум 120.5 хувьтай үнэлэгдэж дундаж **114.7** хувьтай байна.

Д/д	Чиглэл	Нийт үзүүлэлтийн тоо	100-аас дээш хувиар биелсэн	Үүний дотор					Үнэлгээ
				90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/	
1.	Дархан	12	6	3	2	1			101.2
2.	Хонгор	12	9	1	1	1			105

3.	Орхон	12	12						132
4.	Шарынгол	12	10	2					120.5
5.	Ерөнхий дундаж үнэлгээ	48	37	6	3	2			114.7

3.2.4 ГҮЙЦЭТГЭЛ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төлөвлөгөөгөөр нь нийт 25 арга хэмжээг хэрэгжүүлэхээс газар тариалангийн 6 заалтын хэрэгжилтийн дундаж 73.3 хувь, хүнс үйлдвэрлэлийн 4 заалтын дундаж 97.5 хувь, мал аж ахуйн 3 заалтын дундаж 83.3 хувь, мал эмнэлгийн 5 заалтын дундаж 82 хувь, бусад чиглэлээр 7 заалтын дундаж 78.5 хувьтайгаар хэрэгжүүлж **нийт дундаж 81.6** хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хэрэгжилт хангалтгүй буюу 70-аас доош хувь үнэлэгдсэн 14 заалтуудаас дурьдвал:
ХХААЯамнаас 2014 оны үйл ажиллагаанд өгсөн зөвлөмж

- 10.Улаан буудай тариалах талбайг нэмэгдүүлж, рапсын тариалалтыг нийт тариалсан талбайн 20 хувиас хэтрүүлэхгүй байлгах, дотоодын үйлдвэрүүдийг дэмжсэн хүнс, тэжээлийн өндөр ач холбогдолтой уурагт ургамал тариалах бодлого баримтлан хэрэгжүүлэх

Хэрэгжилт-ХХАА-н сайдын 2015 оны 02 сарын 05 ны 01/349, 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 01/695 дугаар албан тоотын дагуу энэ оны рапсын тариалалтад хязгаарлалт хийж 3000 га-аас хэтрүүлэхгүй байхаар үүрэг даалгавар өгсөний дагуу Хонгор сумын ЗДТГазарт болон үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 48 аж ахуйн нэгж, 66 иргэнд албан тоот хүргүүлэн ажиллалаа. Нийт 4809 га-д тосны ургамлын тариалалт хийгдсэн нь нийт тариалах талбайн 38.7 хувийг эзлэсэн байна.

Дархан-уул аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2013, 2014 оны үйл ажиллагаа, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаас өгөгдсөн зөвлөмж /Аймгийн аудитын газар/

- Заалт 22. Хөрөнгийн ашиглалт, тооллогын комиссын гишүүдийн хариуцлагыг сайжруулах, бүртгэлгүй үндсэн хөрөнгүүдийг Төрийн өмчийн хороо болон байгууллагын өмч хамгаалах комиссоор үнэлгээ тогтоолгож, данс бүртгэлд тусгах.

Хэрэгжилт-Байгууллагын үл хөдлөх хөрөнгө барилга, грашийг салгаж үнэлэн данс бүртгэлд тусгах чиглэлээр Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл авсан. Салгаж үнлүүлэхэд гарах зардлыг 2016 оны төсвийн төсөлд тусгаж ХХААЯаманд хүргүүлсэн. Хагас жилийн хөрөнгийн тооллогыг газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг няравын бүртгэлтэй нэг бүрчлэн тулгалт хийж зохион байгуулсан, тооллогоор ямар нэг зөрчил илрээгүй байна. Мөн албан хаагчдын хөрөнгийн бүртгэлийн картгыг шинэчлэх ажлыг зохион байгуулж, эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжрууллаа.

Дээрхээс гадна бусад заалтын хэрэгжилтийг ажлын хэсгээр ярилцаж бодит гүйцэтгэлтэй харьцуулж үнэлгээг хийсэн болно.

Д/д	Салбар, чиглэл	Нийт хэрэгжүүлэхархамжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжихшагандаа	Үүнийдотор					Хугацааболоогүй	Тасарсан		Үнэлгээ
					90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 %/40.0-60%/	30 %/20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалтаас	Хөрөнгийнхүүсвэрээс	
1.	Хүнсний үйлдвэрлэл	4	3	1	1								97.5
2.	Газар тариалан	6	1	5	3	2							85
3.	Мал аж ахуй	3		3	2	1							83.3
4.	Мал эмнэлэг	4		4	3	1							86
5.	Аймгийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	7	2	5	2	1	2						78.5
	Нийт	25	5	20	11	6	2	1					85.2

БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

3.3.1 БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЙЛАН

Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор баталсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын 11 үзүүлэлтийн дундаж 95.45, Хүний нөөцийн бодлогын ил тод байдал 95, Төсөв санхүүгийн ил тод байдал 7үзүүлэлтийн хэрэгжилт 100, Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг тайлант онд худалдан авах ажиллагаа хийгдээгүй тул 2 үзүүлэлтээр үнэлэхэд дундаж 85 хувьтай нийт **ерөнхий дундаж нь 95.7** хувьтай үнэлэгдэв.

Ололттой тал:Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг тухай бүр цахим хуудаст байршуулж ажилласан байна.

- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 33 мэдээллыг цахим хуудаст, фейсбүүк хуудаст 80 мэдээллийг тус байршуулсан.
- Цахим хуудасны танилцуулга хэсэгт байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, түүх, бүтэц зохион байгуулалт, тэргүүлэх чиглэлийг тусгай цэс үүсгэж байршуулсан.
- Цахим хуудасны үйл ажиллагааны ил тод байдал хэсэгт хэсэгт салбарын хууль, тогтоомж, аймгийн хэмжээнд хэрэгжиж буй бодлогын бичиг баримтууд, үйчилгээний жишиг үнэлгээ, салбарын өнөөгийн байдал, шинжилгээний цар хүрээ, төсөл арга хэмжээ, тайлан, төлөвлөгөө, шилэн данс, хүний нөөц, өргөдөл гомдол,

3.3.2 ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Хэрэглэгчийн үнэлгээг “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” ТББ-ын Дархан дахь салбартай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулж ажилласан байна. Нийт асуулга бүхий асуулгын хуудсыг хамтран боловсруулж гэрээний дагуу 520 хэрэглэгчээс хэрэглэгчийн үнэлгээний судалгааны маягтын дагуу судалгааг авсан байна. Үнэлгээний үр дүнг хувьд шилжүүлж тооцоход нийт **18** үзүүлэлтийн **дундаж 72,4 хувьтай** үнэлэгдсэн байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГ ХУВЬД ШИЛЖҮҮЛЖ ТООЦОЖ ҮЗВЭЛ

№	Байгууллагын нэр	ХХААГазрын алба хаагчдын үйлчилгээний үзүүлэлтүүд							Мал эмнэлэг, үржлийн ажил		“Төрөөс малчдын талаар баримтлах боллого”, “Монгол мал” Үндэсний хөтөлбөр	Эрчимжсэн мал аж ахуй манай аймагт хөгжил	Чацаргана хөтөлбөр	Орон нутагт дахь хүнсний үйлдвэрүүдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн технологи, чанар, аюулгүй байдалын үнэлгээ							2015 оны ХХААГ-н үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	Ерөнхий дундаж үнэлгээ
		Мэдээллийн хүртээмжтэй байдал	Хөнгөн шуурхай үйчилгээтэй	Ажилчдын харилцааны соёл	Ажилчдын мэдлэг ур чадвар	Үйл ажиллагааны ил тод байдал	Дарамт чирэгдэл учруулдаг байдал	Шударга байдал	Мал эмнэлгийн чанар үйлчилгээний хүртээмж	Мал эмнэлэг, үржл -ийн үйлчилгээний хөлсний талаар				Гурил	Талх, нарийн боов	Сүүн бүтээгдэхүүн	Хиам, махан бүтээгдэхүүн	Нийтийн хоол үйлдвэрлэлийн салбар				
		1	2	3	4	5	6	7	8	9				10	11	12	13	14	15	16		
1	ДА-ХХААГазар	84	60.5	59.8	70	59.4	87.5	65	73.3	75.7	85.3	69.8	71	85,2	79,8	40,5	69,8	65,2	79.6	72.4		

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДАГАВРЫН ҮНЭЛГЭЭ

3.4.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

Хүнс, Хөдөө Аж Ахуйн Сайдын 2015 оны А/85 тоот тушаал, хавсралтад дурдсан аргалчлалыг удирдлага болгон үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн биелэлтийг үнэлэхэд дундаж нь **100.65** хувьтай үнэлэгдэв.

Салбар тус бүрээр авч үзвэл:

Д/д	Чиглэл	Нийт үзүүлэлтийн тоо	Дүгнэсэн үзүүлэлтийн тоо	100-аас дээш хувиар биелсэн	Үүний дотор					Үнэлгээ
					90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 % /40.0-60%/	30 % /20.0-40%/	10 % /0.0-20%/	
1.	Хүнсний салбар	32	31	18	7	2	2	1	1	99.3
2.	Мал эмнэлгийн салбар	25	12	10	1		1			109.3
3.	Мал аж ахуйн салбар	23	23	15	4	3			1	110.6
4.	Газар тариалангийн салбар	54	50	19	6	11	9	5		83.4
5.	Нийт	134	116	62	18	16	12	6	2	100.65

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХХААГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ

Д/д	Дүгнэх үзүүлэлт	Зорилтын тоо	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	Бүрэн биелсэн	Хэрэгжих шатандаа	Үүнийдотор					Хугацаа болоогүй	Тасарсан		Үнэлгээ
						90 % /80.0-100%/	70 % /60.0-80%/	50 %/40.0-60%/	30 %/20.0-40%/	10 % /0.0-20%/		Зохионбайгуулалт аас	Хөрөнгийн эх үүсвэрээс	
Нэг. Бодлогын зорилтын хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээ														
1.	Дархан-Уул аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /2013-2016 он/	18	41	10	31	18	11	1	1					84.6
2.	“Хүнсний аюулгүй байдал аймгийн дэд хөтөлбөр батлах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012.05.10-ний өдрийн 39 дугаар тогтоол	12	14	7	7	6			1					90.7
3.	Монгол мал үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2015 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө		12	8	4	4								96.6
4.	“Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих дэд хөтөлбөр батлах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 26 дугаар тогтоол	2	20	8	12	7	3	2						87.3
5.	“Чацаргана аймгийн дэд хөтөлбөр батлах тухай” аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2011.04.14-ний өдрийн 23 дугаар тогтоол	3	7	7		6	1							93.8
6.	Аймгийн нийгэм, эдийн засгийг 2015 онд хөгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	2	2	1	1	1								95

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗД, ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилт, ХХАА-н салбарт хэрэгжиж буй 4 дэд хөтөлбөр, хэрэглэгчийн үнэлгээ, Аймгийн эдийн засаг, нийгмийг тухайн онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн үнэлгээг АЗДТГ-ын ХШҮ-ний тасгийн өссөн болон тухай жилд хийхээр төлөвлөсөн арга хэмжээний үнэлгээгээр, Газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, Хүнс, хөдөө аж ахуйн сайдаас ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Сумдын мал эмнэлэг, үржлийн тасагтай байгуулсан тухайн жилийн хамтран ажиллах гэрээний биелэлт, Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлт, Байгууллагын үйлажиллагааны ил тод байдлын тайлан, Үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн заалт бүрийн биелэлтэд ХШҮнэлгээ хийхэд ерөнхий дундаж нь **92.1** хувьтайгаар дүгнэгдэв.

Дархан-Уул аймгийн ИТХТ-ийн 2009 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх бодлого"-ын хавсралтаар баталсан 2020 онд хүртэлх ХХАА-н төсөөлөл тооцоололд үндэслэн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийн зорилтот түвшин тооцсон сайн талтай байна.

ТАВ. САНАЛ

Хөрөнгө зардал ихээр шаардсан заалтуудыг төсвийн төлөвлөлттэй уялдуулж, жил, жилийн төлөвлөгөөнд оруулж байх.

Сум бүрт жишиг хоршоог байгуулж үйлдвэрлэлт-боловсруулалт-тээвэрлэлт-хуваарилалт-борлуулалт-хэрэглэгчид хүргэх гинжин сүлжээг энэхүү хоршоогоор дамжуулж хэрэгжүүлэн мал, тариаланчдын гар дээр ирэх орлогыг нэмэгдүүлэх. Сум бүрт хоршооны сургагч багш бэлтгэх ажлыг дахин зохион байгуулж, хоршооны хүний нөөцийг бэлтгэх, малчид, тариаланчдын хоршооны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх чиглэсэн арга хэмжээг жил бүр төлөвлөж зохион байгуулах.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоог сайжруулж,зохион байгуулалтаас хэрэгжилт хангалтгүй байгаа заалтуудыг жилийн ажлын төлөвлөгөө болон албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тусгаж эрчимжүүлэх чиглэлээр ажиллах.

Аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсвөөс тодорхой хувийг гаргаж санхүүжүүлэх тал дээр анхаарч ажиллах

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан болон бусад гадаад, дотоодын зээл, тусламжаар хэрэгжиж төслүүдэд бодлого, зорилтод тусгагдсан зээл, тусламжаар хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг хамруулж, жил жилийн тэргүүлэх чиглэлд тусгуулахад анхаарах.

Төлөвлөлтөд тусгагдаагүй, хөрөнгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй, хэрэгжүүлэх чиглэл, арга хэлбэр нь тодорхой бус, бэлтгэл ажил хангагдаагүй арга хэмжээнүүдийг анхааралдаа авч, хэрэгжилтийг оновчтой зохион байгуулах.

Танилцсан: ХХААГ-ын дарга

Ц.Энхжаргал

**Хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн:** ХШҮ-ын багийн ахлагч

Б.Бат-Эрдэнэ

2016-01-21

Огноо